



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/60

Сант сум

2023 оны Тээврийн хэрэгслийн шинэчилсэн
бүртгэл, үзлэг тооллого явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, 59.1.23, Автотээврийн тухай хуулийн 7.1.1, 7.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/150 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийг шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогод хамруулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулсугай.

2. Тээврийн хэрэгслийн улсын шинэчилсэн үзлэг, тооллогын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнх-Эрдэнэ

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Т.Буяндэлгэр

(Татварын улсын байцаагч)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Ж.Лхагважаргал

(Хэсгийн төлөөлөгч)

3. Тээврийн хэрэгслийн улсын шинэчилсэн үзлэг тооллогыг сумын хэмжээнд удирдамжийн дагуу чанартай зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчилан таниулах, техник хэрэгслийг бүрэн хамруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Улсын үзлэгийн хэрэгжилтийн дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

d/disk 2023 on zahiramj

4 3 1 5 1 0 6 0

Боловсруулсан: *М. Гундугаар*
Хянасан: *Ч. Амарал*
Хувь: *1*
Огноо: *2011.04.16*